



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/939

Улаанбаатар хот

Гэрээний загварыг шинэчлэн батлах тухай

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар төмөр замын “Эзэмшигчийн эзэмшлийн дагнасан хэрэглээний салбар замд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээ”-ний загварыг шинэчлэн 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Тушаалаар батлагдсан гэрээний загварыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (Ц.Ариунболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Замын даргын 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/210 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга (Д.Амарбаясгалан)-д даалгасугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601236210

УБТЗ-ын даргын 2023 оны дүгээр
сарын-ны өдрийн тоот
тушаалын 01 дүгээр хавсралт



**..... эзэмшигчийн эзэмшил /баланс/-ийн дагнасан хэрэглээний
салбар замд УБТЗ ХНН-ийн сэлгээний зүтгүүрээр вагон
тавьж өгөх, татаж авах тухай гэрээ**

202.. оны дугаар
сарын-ний өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү Эзэмшигчийн эзэмшлийн дагнасан хэрэглээний салбар замд УБТЗ ХНН-ийн зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах гэрээ /Цаашид “Гэрээ” гэх/-г

Нэг талаас: Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг, түүнийг итгэмжлэлээр төлөөлж Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга албан тушаалтай (цаашид “УБТЗ” гэх),

Нөгөө талаас: Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Регистрийн дугаартай, түүнийг төлөөлж албан тушаалтай (цаашид “Эзэмшигч” гэх) нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол улсын Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үндэсний стандарт, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас баталсан дүрэм журам, Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр /ОАХХ/, Ачааны вагон эдэлгээний дүрэм /АВЭД/, Нэгдсэн нэвтрэх тариф /ННТ/, УБТЗ-д мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавар, Тарифын мөрдлөгийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Ерөнхий зүйл.

1.1.1. УБТЗ-ын сэлгээний зүтгүүрээр үйлчилдэг -ийн эзэмшлийн бөгөөд өртөөний-р замд-р сумаар нийлэх салбар замыг дээр дурьдсан хууль, дүрэм, журам, заавар, хэлэлцээр, тариф зэргийг үндэслэн вагоныг тавьж өгөх, татаж авах үйл ажиллагааг гүйцэтгэх, ажил үйлчилгээний хөлсний төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд саадгүй төлж барагдуулах харилцааг зохицуулахад оршино.

1.1.2. Салбар замын мэдээлэл:

- Салбар замын зааг /хил/ нь.....өртөөний-р замд-р сумаас .. м зайд байрлуулсан-ийн тэмдэг болно.
- Салбар замын ачилт, буулгалтын талбарт, татаж авах, сэлгээний ажлыг УБТЗ-ын зүтгүүрээр гүйцэтгэнэ.
- Салбар замын нийт дэлгэмэл урт метр, нийт вагоны фронттой.
- Салбар зам нь..... дугаарын ширхэг суман шилжүүлэгтэй.
- Салбар зам нь ПК..... байрлах ,нийт ширхэг гарамтай.
- Салбар зам нь..... -ийн эзэмшлийн зам.
- Салбар замын уртаас хамааран нэг удаад нэгэн зэрэг тавьж өгч ачиж, буулгах вагоны тоог зам тус бүр дээр дараах байдлаар тогтоов. Үүнд:
Ачаа буулгахад: /вагоны тоо, төрөл/
Ачаа ачихад: /вагоны тоо, төрөл/

Нэгэн зэрэг/вагоны тоо/ вагон ачиж,/вагоны тоо/ вагон буулгана.
/Жич: 2 ба түүнээс дээш замтай бол зам тус бүрээр нь урт, ачилт, буулгалтыг тодорхойлон бичих/

- 1.1.3. Энэхүү гэрээний хугацаанд, гэрээтэй холбогдолтой зохих эрх зүйн акт, тухайлбал тээврийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд УБТЗ нь Эзэмшигчид "Төмөр замын тээврийн тухай хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Тарифын өөрчлөлтийг тушаалд дагаж мөрдөхөөр заагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

1.2 Гэрээний хавсралтууд:

- 1.2.1. Дараах бичиг баримтуудыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.Үүнд:

- Эзэмшигчийн, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулах/
- Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулах/
- Захирлын иргэний үнэмлэхийн хуулбар /нотариатаар баталгаажуулах/
- Салбар зам арчлалтын гэрээ
- Хэрвээ өөрийн эзэмшлийн салбар зам биш бол шилжүүлсэн ба түрээслэсэн гэрээ /нотариатаар баталгаажуулах/
- Салбар замын ачиж, буулгах, зөөх тоног төхөөрөмжийн жагсаалт болон техникийн паспортын хуулбар
- Салбар замын техникийн байдал тогтоосон акт
- Салбар замд ачаа ачиж буулгах технологит ажиллагааг тогтоосон акт
- Салбар замын дэвсгэр зураг, хөндлөн дагуу огтлолын зураг
- Хэрэв гарамтай бол ЗТХЯ-наас олгосон гармын зөвшөөрөл, зураг
- Эзэмшигчийн зүтгүүрээр сэлгээний ажил гүйцэтгэх заавар
- Бусад холбогдох баримтууд /хавсаргасан бичиг баримтны нэршил /

бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна. Баримт бичгийг УБТЗ-д өгч чадаагүйгээс цаг тухайд нь бүрдүүлж өгөөгүйгээс холбогдон гарах зардлыг Эзэмшигч өөрөө хариуцна.

Хоёр. УБТЗ -ЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. УБТЗ нь ачаа коммерийн ажлыг зохион байгуулах чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.
- 2.1.1. УБТЗ-ын эзэмшлийн вагоныг ачилтанд цэвэрлээгүй тавьж өгсөн тохиолдолд түүнийг цэвэрлэсэн хугацааг вагон ашиглалтын хөлс тооцоход оруулахгүй.
- 2.1.2. Ачилт, буулгалтанд ирсэн вагоныг өртөө нь эзэмшигчийн ачилт, буулгалтын замд /эзэмшигчийн өөрийн сэлгээний илчит тэргээр үйлчилж байгаа бол өртөөний вагон дамжуулан хүлээлцэх замд /тавьж өгч татаж авч үйлчлэх, ачаа өртөөнд ирсэн тухай мэдэгдлийг салбар зам эзэмшигчийн тоот утсанд ачаа өртөөнд ирсэн дариуд мэдэгдэх үүрэгтэй. Салбар зам эзэмшигчийн буруугаас ачаа ирсэн тухай мэдэгдэж чадаагүй эсвэл, ачааны ажиллагаанд тавих вагоны тоо ачилт буулгалтын фронтын уртаас хэтэрсэн, уг салбар зам эзэмшигчийн болон дайвар үйлчлүүлэгчийн хаягаар өртөөнд нэмж вагон ирсэн, зам сум нь гэмтэл зөрчилтэйн улмаас сэлгээний ажлыг зогсоосон тохиолдолд хүлээлгийн санамжийг ачааны ажиллагаанд вагон өртөөнд ирсэн цагаас технологит ажлын хугацааг хасаж тооцон нээж, вагон болон зам ашиглалтын хөлс хураамжуудыг тооцон авна.
- 2.1.3. Ачаа ирсэн тухай болон, вагон тавьж өгөх, татаж авах тухай мэдэгдлийг УБТЗ-д мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу өгч мэдэгдлийн дэвтэр хөтөлнө.
- 2.1.4. Салбар замд тавигдсан вагонуудыг дугаарчилсан аргаар бүртгэж санамж хөтөлнө.
- 2.1.5. УБТЗ нь задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны байрлал, бэхэлгээ, овор хэмжээнд тохирч байгаа эсэх, ломбоны байдал, тээврийн бичиг баримтын бичилт, бүрдэлтийг сайтар шалгаж тээвэрлэлтэнд хүлээн авах үүрэгтэй.

2.1.6. Эзэмшигчийн замыг харъяалж буй УБТЗ-ын болон зам засварын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий зам засварын газраас салбар зам эзэмшигчийн захиалгаар болон зам, сум, гарам, хиймэл төхөөрөмж, байгууламжинд үзлэг хийх явцад зайлшгүй солих, засвар үйлчилгээ хийх шаардлагатай гэмтэл илрүүлбэл салбар зам эзэмшигчид мэдэгдэж гэмтлийн акт тогтоож, гэмтлийг засварлах ажлыг гүйцэтгэнэ. Сэлгээний хөдөлгөөнд саад учруулахуйц гэмтэл илэрсэн бол уг зам, сумыг гэмтлийг арилгатай өртөөний дарга, замын мастер сэлгээний хөдөлгөөнд хаах хүртэл арга хэмжээ авна.

2.1.7. Салбар замд бүлгээр тавьж өгсөн вагонуудыг хэсэгчлэн татаж авсан бол санамжийг хэсэгчлэн хааж, хэсэгчлэн татаж авсан тохиолдол тус бүрээс тавилт таталтын хөлс тооцно.

2.2. УБТЗ нь сэлгээний болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.

2.2.1. УБТЗ нь салбар замд зам, сумын үзлэгийг УБТЗ-д мөрдөгдөж буй төмөр замын тээврийн дүрэм журамд заасан хугацаанд хийнэ.

2.2.2. УБТЗ нь дайвар үйлчлүүлэгчийн вагон, чингэлгийг салбар замд тавьж өгөх, татаж авахдаа салбар зам эзэмшигчтэй байгуулсан энэхүү “Салбар зам ашиглах, вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээ”-д заасны дагуу үйлчилнэ.

2.2.3. Эзэмшигчийн ачилтын төлөвлөгөө гэрээ, захиалгаар тухайн ачаа тээвэрлэхэд тохирч тэнцэх вагоноор хангах үүрэгтэй бөгөөд цэвэрлээгүй хөдлөх бүрэлдэхүүнийг зөвхөн ачаа илгээгчийн зөвшөөрөлтэйгээр тавьж өгч болно.

2.2.4. УБТЗ нь ачааг хүлээн авсан агшнаас эхлэн бүрэн бүтэн байдлыг нь хариуцан хүргэх хугацаанд нь ачаа хүлээн авагчид хүргэж өгөх.

2.2.5. УБТЗ нь /өртөө нь/ өөрийн сэлгээний зүтгүүрээр үйлчилж салбар замд вагоныг тавьж өгч байгаа тохиолдолд салбар зам эзэмшигчийн ивүүрээр вагоныг бэхэлж салбар зам эзэмшигчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

2.2.6. УБТЗ, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр эзэмшигчийн замд өөр байгууллагын вагоныг ачилт, буулгалтын ажиллагаанд тавьж өгч болохгүй.

2.3. УБТЗ нь ачаа коммерийн ажлыг зохион байгуулах чиглэлээр дор дурдсан эрх эдлэнэ.

2.3.1. УБТЗ нь салбар зам эзэмшигч ба түүгээр үйлчлүүлэгч байгууллагын УБТЗ-аар тээвэрлүүлж байгаа ачааны тээвэрлэлтийг зөв зохион байгуулахад үйлчлүүлэгчийн өгсөн захиалгыг тогтоосон хугацаанд тээвэрлэгчид өгөх, зөвшилцөн баталгаажуулах.

2.3.2. УБТЗ нь үйлчлүүлэгч байгууллагаас ачааны захиалгыг тогтоосон хугацаанд “Ачаа тээврийн цахим үйлчилгээний систем” программаар эсвэл албан бичгээр дамжуулан хүлээн авна. Ачааг илгээх, хүлээн авах тухай хөрш орнуудын төмөр замаас ирсэн захиалга, зөвшөөрлийг үндэслэн тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2.3.3. УБТЗ нь үйлчлүүлэгч байгууллагаас орон нутгийн харилцаанд тээвэрлэх ачааны жилийн захиалгыг тухайн он гарахаас 2 сарын өмнө, сарын тухайн сар эхлэхээс 10 хоногийн өмнө хүлээн авна.

2.3.4. Ачаа тээвэрлэлтийн тооцоог “Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем” програм ашиглан талууд хянаж байна.

2.3.5. УБТЗ нь салбар замаар ачаа ачих зөвшөөрөл, ачилтын гэрээ, захиалгатай боловч төлбөрийн чадваргүй байгууллагын ачааг ачуулах, хүлээн авахыг хориглох.

2.3.6. УБТЗ нь тухайн салбар замаас түрүүчийн ачуулсан ачааг хүлээн авагч авахаас татгалзах буулгаж авахгүйгээр удаан хугацаагаар зогсоох, хилийн болон зам зуурын өртөөдөд ачаа илгээгч болон хүлээн авагчийн буруугаас вагон саатвал дараагийн ачааг ачихыг зогсоох буюу хязгаарлах.

2.3.7. УБТЗ нь тээврийн хөлс, сэлгээний зардал, вагон ашиглалтын хөлс, вагон тавьж өгч, татаж авсны хөлс, түрээсийн хөлс зэрэг бусад ажил үйлчилгээний хөлсийг зээл тооцоогоор хийхийг хориглоно.

- 2.3.8. Эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрсэн тохиолдолд үүргээ биелүүлэхийг шаардах, удаа дараа биелүүлээгүй тохиолдолд энэ талаар бичгэн мэдэгдэл өгч үйлчлэхгүй байх.
- 2.3.9. Эзэмшигч болон дайвар үйлчлүүлэгч нь төлөвлөгөө гэрээтэй болон захиалгатай вагоноо салбар зам дээрээ тавиулаад хоногтоо багтааж ачаалахгүй зогсоовол өдөр бүрийн ачих вагоны тоо хангалтанд нь тухайн вагоныг оруулж тооцох.
- 2.3.10. Энэхүү гэрээний хавсралт болох “Салбар замд ачаа ачиж буулгах технологит ажиллагааг тогтоосон акт”-д заасан хугацааг баримтлан эзэмшигч ачилт буулгалтын ажлыг хоногийн турш зохион байгуулан ажиллах.
- 2.3.11. Ачааны үлдэгдэлтэй болон бэхэлгээний материал эвдэж гэмтээсэн буюу ачилтын зөрчилтэй вагоныг салбар замаас тухайн зөрчлийг арилгатай татаж авахгүй бөгөөд санамжийг хаахгүй байх.
- 2.3.12. Анхны ачаа хүлээн авагч нь ачаа ирсэн өртөөтэй тээвэрлэлттэй холбогдсон бүх тооцоог хийсний дараа УБТЗ нь ачааг эзэнд нь олгоно.

2.4. УБТЗ нь сэлгээний болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах чиглэлээр дор дурдсан эрх эдэлнэ.

- 2.4.1 Сэлгээний хөдөлгөөнд саад учруулах буюу хөдөлгөөний аюулгүй байдалд харшлах ямар нэгэн зөрчил салбар зам дээр илэрсэн тохиолдолд замын мастер, бригадын даргын мэдэгдлээр, УБТЗ-ын “Хяналтын албаны байцаагч” болон уг салбар зам харъяалагдах хэсгийн “Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан байцаагч”-ийн мэдэгдэл болон өртөөний даргын шийдвэрээр уг салбар замыг сэлгээний хөдөлгөөнд хаана.

Гурав. Эзэмшигчийн үүрэг, эрх

3.1. Эзэмшигчийн хүлээх үүрэг:

- 3.1.1. Өөрийн эзэмшлийн салбар замыг бүхэлд нь хянах чадвар бүхий нэг сарын хугацаанд бичлэгээ хадгалах багтаамжтай хяналтын камераар тоноглогдсон байна.
- 3.1.2. Салбар зам нь тоот харуулын утасны дугаарыг байнгын ажиллагаатай байлгана.
- 3.1.3. Салбар замын авто болон төмөр замын гарц хаалгыг сэлгээний хөдөлгөөн болон авто машины хөдөлгөөн хийгдэхээс бусад үед хаалгыг хааж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, аюултай бүсэд мал орсноос үүдэн гарсан хохирлыг бүрэн хариуцна.
- 3.1.4. Алсдагдсан зайтай /3км-ээс дээш/ салбар замруу технологит ажиллагааг гүйцэтгэхэд АВХ-г автомашинаар үнэ төлбөргүй хангана.
- 3.1.5. Эзэмшигч нь ачилт, буулгалтын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ерөнхий шаардлага Монгол улсын стандарт MNS-3084:2023-ыг удирдлага /мөрдлөг/ болгон ачилт, буулгалтын ажлыг гүйцэтгэнэ.
- 3.1.6. Эзэмшигч нь салбар замынхаа төхөөрөмж, байгууламж, тоноглол, механизмыг Монгол улсын стандарт MNS-5833:2014-ыг удирдлага /мөрдлөг/ болгон оврын шаардлагыг хангасан байна.
- 3.1.7. Салбар зам эзэмшигч нь Монгол улсын стандарт MNS-45001:2018 /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо/-ыг удирдлага /мөрдлөг/ болгон ХАБЭА-г хангасан байна.
- 3.1.8. Эзэмшигч нь ачааг вагоноос үлдэгдэлгүй буулгаж бэхэлгээний материалыг бүрэн авч вагоныг цэвэрлэн хаалга, хашлага, нээлхий, таг, хүйсийг бүрэн хааж УБТЗ-д хүлээлгэн өгнө.
- 3.1.9. Салбар замд тавигдсан вагоны болон ачааны бүрэн бүтэн байдлыг хариуцах ба өөр байгууллагуудад өөрийн салбар зам дээр ачаа ачих, буулгах зөвшөөрөл өгсөн тохиолдолд тухайн салбар замаас ачаатай вагоныг өртөөний замруу татах хүртэл ачаа, вагоны бүрэн бүтэн байдлыг салбар зам эзэмшигч бүрэн хариуцна.
- 3.1.10. Эзэмшигч нь ачааг ачихаас өмнө сав, баглаа боодол, таар шуудай, хайрцаг, ачмаг бэхэлгээний хэрэгсэл, ломбоны хавчаар тугалгын хамт, дулаалгын материал, мал

- амьтны тэжээл /ачаа дагалдагч/ зэрэг зүйлийг урьдчилан бэлтгэж ачих ачааныхаа захиалга өгч /гэрээ хийж/ зөвшөөрөл авч гэрээ, лизенц, гаалийн мэдүүлэг, счёт фактур, мал эмнэлэг, ургамал, хорио цээр, ариун цэврийн гэрчилгээ, чанарын тодорхойлолт бусад дагалдах бичиг баримтуудыг бүрэн бүрдүүлнэ.
- 3.1.11. Экспорт, импорт /резкспорт/ болон орон нутгийн ачааны харилцааны тээврийн бичиг баримтад хүрэх өртөөний нэр, код, ачааны нэр, жин, байрын тоо, ачаа хүлээн авагчийн шуудангийн хаяг, гэрээний дугаар, /харилцах данс, банкны нэр/ утас, телекс, факсын дугаар зэргийг үнэн зөв тодорхой заасан байна.
- 3.1.12. Эзэмшигч нь өөрийн эзэмшлийн салбар замынхаа гармыг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Төмөр замын гарам ашиглах журам”-ын шаардлагад нийцүүлэн ашиглах, зам, сум, гармыг хог хаягдал, цас мөснөөс байнга цэвэрлэх, бүрэн бүтэн байлгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.
- 3.1.13. Эзэмшигч нь төмөр замын тээвэрлэлттэй холбогдсон ажил үйлчилгээний хөлс /тээвэрлэлтийн болон сэлгээ, вагон ашиглалт, вагон тавьж өгсөн, татаж авсан бусад ажил үйлчилгээний хөлс, хураамж/-ийг УБТЗ-д мөрдөгдөж байгаа ачаа тээвэрлэлтийн тарифийн мөрдлөгөд заасан тарифаар төлөх бөгөөд дүрэм, журамд заасан хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг УБТЗ-д төлнө.
- 3.1.14. Салбар замын зам сумын үзлэгт өртөөний дарга, арчлагч байгууллагын мастер, салбар зам эзэмшигч талаас дарга нар оролцож хамтарсан үзлэг шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ. Салбар замд үзлэг шалгалт хийсэн хөлсийг ачаа тээвэрлэлтийн тарифт зааснаар жилд салбар замын дэлгэмэл уртын нэг километр бүрт төгрөгөөр бодож нийт км төгрөгийг тухайн оны эхний улиралд багтаан төлнө.
- 3.1.15. Түргэн гэмтэх ачаа, мал амьтан ачсан вагоныг цэвэрлэж, ариутгаж хүлээлгэж өгнө.
- 3.1.16. Вагоныг бүрэн цэвэрлээгүй тохиолдолд тарифт зааснаар вагоны цэвэрлэгээ, хөлсийг УБТЗ-д төлнө.
- 3.1.17. Задгай хөдлөх бүрэлдэхүүн (тавцан вагон, транспортер) дээр хэт хэтрүү, хэтрүү овортой ачаа тээвэрлэх тохиолдолд ачих ачилтын зургийг бэхэлгээний тооцооны хамтаар үйлдэж УБТЗ-аар хянуулан батлуулах, ачааны жин, тоо ширхэгийг зөв тогтоож тээврийн бичиг баримтад заасан байна.
- 3.1.18. УБТЗ-аас тавьж бэхэлж өгсөн вагоныг өөрөө өнхрөхөөс хамгаална. Үүний тулд вагоны бэхэлгээ болох ивүүрт "..." гэсэн тэмдэг тавьж, улаан будгаар будсан №..... дугаар бүхий ширхэг тормозны ивүүртэй байна.
- 3.1.19. Тормозны ивүүрийг тусгай саванд хадгална. Вагоныг тавьж өгөх үед харуул нь шаардлагатай тооны ивүүрийг найруулагчийн бригадад өгч зам тус бүрт тооцоот ивүүрээр даруулж бэхлүүлнэ. Вагоныг бэхэлсэн эсэхэд өөрийн ажилтнаар хяналт тавиулж ивүүрийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаална.
- 3.1.20. Энэхүү гэрээнд зааснаар найдвартай зөв бэхэлгээ хийгээгүйгээс болж гологдол, осол, сүйрэл гарвал хариуцлагыг хүлээнэ. Салбар замд зогсож байгаа вагоныг гараар /бусад аргаар/ байрнаас нь хөдөлгөх тоормозны ивүүрээс бусад зүйлээр орлуулж бэхлэхийг хатуу хориглоно.
- 3.1.21. Шөнийн цагт /үзэгдэлт муутай өдөр/ зам, сум, талбайг гэрэлтүүлгээр хангах, өдөр, шөнө, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр тасралтгүй ачилт, буулгалтын ажлыг зохион байгуулна.
- 3.1.23 Салбар зам эзэмшигч нь өөрийн эзэмшлийн зам, талбайн хүчин чадал, өртөөний хоногийн ажлын боловсруулах хүчин чадалд тохируулан ачаа боловсруулах үйл ажиллагааг төлөвлөж, дайвар үйлчлүүлэгчийн захиалгыг хүлээн авна.
- 3.1.24 Энэхүү гэрээний 3.1.23-т заагдсан үүргээ биелүүлээгүйгээс өртөөний болон зам зуурт хүлээлгэнд зогсоосон өөрийн болон дайвар үйлчлүүлэгчийн вагонуудын зам ашиглалтын хөлстэй холбоотой төлбөр хураамжийн үнийн дүнгийн 20%-тай тэнцэх торгуулийг “УБТЗ”-д салбар зам эзэмшигч төлж барагдуулна.
- 3.1.25 Салбар зам эзэмшигч нь энэхүү гэрээний 3.1.23, 3.1.24 -д заасан үүргээ биелүүлээгүй, төлбөр, хураамжийг төлөөгүй тохиолдолд УБТЗ нь тухайн салбар замд үйлчлэхээс

- татгалзан тухайн салбар замыг хаах эрхтэй ба холбогдох аливаа бүх төлбөр, хураамжийг салбар эзэмшигч бүрэн хариуцна.
- 3.1.26 Эзэмшигч нь өөрийн зам, талбайд байгаа өргөх, зөөх, машин механизм түүний аюулгүй ажилгаанд бүрэн хяналт тавина. Мөн зам, талбайд сэлгээний ажил хийх үед сэлгээний хөдөлгөөнд саад болох өргөх зөөх машин механизм, авто тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон байна.
- 3.1.27 Эзэмшигч нь “Аюултай ачаа тээвэрлэх эрхийн зөвшөөрөл”-ийг холбогдох газраас авсан өөрийн салбар зам нь аюултай ачаа ачиж буулгахад хаалттай тохиолдолд “УБТЗ-аар аюултай ачаа тээвэрлэх журам”-ын заалтын дагуу уг ачааг аюултай ачаа ачиж, буулгах нээлттэй өртөөний салбар замд ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.
- 3.1.28 Нэг замд хэд хэдэн хэрэглэгчийн салбар зам байрласан тохиолдолд эхний хэрэглэгч дараагийн болон төгсгөлийн хэрэглэгчийн салбар замд вагоныг тавьж өгөх, татаж авах үйл ажиллагаанд саад тотгор учруулахгүйгээр ажлыг гүйцэтгүүлэх үүргийг хүлээсэн нотолгоо баримтыг бичгээр авч салбар замын гэрээнд хавсаргасан байна. Хэрвээ нотолгоо баримтыг зөрчиж ямар нэг хориг тавьж таталт, тавилтыг саатуулснаас үүдэн гарах хариуцлагыг нотолгоо баримтад заагдсан хариуцагч салбар зам эзэмшигч хариуцна.
- 3.1.29 Үндэсний стандартын шаардлага болон вагонд ачаа ачих, буулгах технологи зөрчснөөс шалтгаалан вагон, хөдлөх бүрэлдэхүүн гэмтээсэн, үйлчлүүлэгчийн буруутай үйлдлээс УБТЗ-д ямар нэгэн хохирол, өр авлага учирсан тохиолдолд салбар зам эзэмшигч бүрэн хариуцан барагдуулна.
- 3.1.30 Ачаа илгээгч, хүлээн авагчийн буруугаар өртөө болон салбар зам дээр вагон /чингэлэг/ эвдэж гэмтээвэл учруулсан хохирлыг тухайн цаг үеийн үнэ, ханшаар тооцож нөхөн төлнө.
- 3.1.31 Эзэмшигч өөрийн эзэмшлийн салбар замд УБТЗ-ын ажилтныг гэрээгээр ажиллуулсан тохиолдолд хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.
- 3.1.32 Эзэмшигч нь эзэмшилдээ байгаа салбар зам, бусад байгууламжийг зохих дүрэм, стандартын шаардлагын хэмжээнд арчлаагүйгээс хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаагүй тохиолдолд түүнээс үүдэн гарах хохирол, хариуцлагыг салбар зам эзэмшигч бүрэн хариуцна.
- 3.1.33 Өөрийн салбар замаар ачилт буулгалтанд ирсэн вагоныг өртөөний зам дээр 12 цагаас дээш зогсоохгүй байх, зогсоосон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 3.1.34 Эзэмшигч нь ачилтын захиалгыг УБТЗ ХНН-д дараах хугацаанд “Ачаа тээврийн цахим үйлчилгээний систем” програм эсвэл албан бичгээр дараах тогтоосон хугацаанаас хоцроолгүй өгөх үүрэгтэй. Үүнд:
- а. Орон нутаг болон олон улсын харилцаанд тээвэрлэх ачааны жилийн захиалгыг тухайн он гарахаас 2 сарын өмнө, тээвэр зохион байгуулалтын албанд
 - б. Сарын захиалгыг олон улсын харилцаанд тухайн сар эхлэхээс 15 хоногийн өмнө, тээвэр зохион байгуулалтын албанд
 - в. Сарын захиалгыг орон нутгийн харилцаанд тухайн сар эхлэхээс 10 хоногийн өмнө, тээвэр зохион байгуулалтын албанд
 - г. Хоногийн захиалгыг ачилт хийхээс өмнөх өдрийн 14:00 цагаас өмнө, ачилт хийх өртөөнд, тус тус өгнө.
- 3.1.35 Эзэмшигч нь өөрийн өгсөн захиалгын дагуу УБТЗ –ын хангасан вагоныг ачаагүй болон гэрээт захиалгаас татгалзсан тохиолдолд УБТЗ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Тарифын 1-р мөдлөгө”, дүрэм, журам, тушаалд заасны дагуу төлбөр төлнө.
- 3.1.36 Эзэмшигч нь салбар зам ашиглалтын гэрээний үндсэн дээр ашиглаж буй замыг бусдад буюу тухайн салбар замаар ачаа ачиж буулгаж буй ачаа илгээгч, ачаа хүлээн авагч нарт ямар нэгэн саадгүйгээр үйлчлүүлэх боломжийг олгох үүрэгтэй. Хэрэв саад учруулсан, хаалт хориг тавьсан тохиолдолд энэхүү гэрээний биелэлтийг түдгэлзүүлэх, вагон тавьж өгөх татаж авах ажиллагааг зогсоох үндэслэл болох бөгөөд УБТЗ нь үүнээс үүдэн гарсан аливаа асуудалд хариуцлага хүлээхгүй.
- 3.1.37 Агаарын температурын эрс өөрчлөлттэй хавар, намрын улиралд физик, химийн шинж чанар нь галын аюултай /нүүрс, үртэс гэх мэт/ ачааг вагонд ачихдаа Монгол улсын

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2 зүйл, 19 дүгээр зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

- 3.1.38 Физик, химийн шинж чанараараа чийг авсанаас өөрөө уугиж шатах, нөхцөл бүрддэг, чийгтэй, халалт үүссэн /тухайн үеийн агаарын температурас хэт их давж халсан/ зэрэг гал гарах эрсдэлтэй үед ачааг вагонд ачихгүй байх. Энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх эрсдэл, хохиролыг УБТЗ ХНН хариуцахгүй.
- 3.1.39 Эзэмшигчийн салбар замд хууль, дүрэм, журам, тушаалыг зөрчсөнөөс хөдөлгөөний аюулгүй байдал болон ХАБЭА-тай холбоотой үүдэн гарах аливаа өр төлбөр, хохирлыг бүрэн хариуцна.

3.2. Эзэмшигч дор дурдсан эрх эдлэнэ.

- 3.2.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс салбар зам эзэмшигчид учирсан тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой хохирлыг барагдуулахыг УБТЗ-аас шаардах.
- 3.2.2. Хэрэв ачилтанд тэнцэхгүй вагон тавьж өгсөн тохиолдолд тэнцэх өөр вагоныг тавьж өгөхийг УБТЗ-аас шаардах.
- 3.2.3. Төмөр замын тавьсан акт, ноогдуулсан анзыг хуулийн үндэслэлгүй гэж үзвэл холбогдох журмын дагуу гомдол, нэхэмжлэлээ гаргах.

Дөрөв. Хамтран хүлээх үүрэг, хариуцлага

- 4.1. Вагон ба ачааг "....." ХХК-ийн замууд дээр салбар зам эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Талбайн эрхлэгч /экспедитор/, УБТЗ-ын төлөөлөгч ачаа вагон хүлээлцэгч нар хамтран үзлэг хийж хүлээлцэнэ. Вагоны эвдрэл гэмтэлгүй дээд болон хажуугийн нээлхийнүүд, хашлага, хаалга, цүү /тусгай зориулалтын вагоны таг, хүйс нь хаалттай бүрэн эсэх, ломбо нь бүрэн бүтэн гэмтэлгүй, задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны байдал, бэхэлгээ/ зэргийг сайтар шалгаж хүлээлцэх ёстой. Хэрэв техник коммерийн ямар нэгэн зөрчил илрүүлбэл энэ тухай акт тогтооно. Вагон, ачааг хүлээж авч байгаа тал нь энэ тухай АВХ-ийн санамжинд актны дугаарыг бичиж тэмдэглэнэ.
- 4.2. Ачааг буруу бэхэлж ачсан, тээврийн бичиг баримтыг буруу зөрүү үйлдсэн, ачааны хаяг тодорхой бус тээврийн дагалдах бичиг баримтыг дутуу буруу явуулснаас болж гарах хохирлын хариуцлагыг Эзэмшигч хүлээнэ.
- 4.3. Эзэмшигчийн замд сэлгээний хөдөлгөөнд аюул учруулж болох эвдрэл гэмтэл сааталтай байвал УБТЗ салбар замд вагон тавьж өгөх татаж авах ажлыг зогсоож уул эвдрэл гэмтлийг засаж дуусах хүртэлх хугацаанд салбар замд зогсож байгаа вагоны санамжийг хаахгүй бөгөөд өртөөн дээр зогсож байгаа вагонд хүлээлгийн санамж нээж вагон ашиглалтын хөлсийг тооцож салбар зам Эзэмшигчээр төлүүлнэ.
- 4.4. Эзэмшигч нь ачилт буулгалтанд тавигдсан вагонуудыг бүрэн ачиж буулгаж дуусмагц нь УБТЗ-ын өртөөний тоот утсаар мэдэгдэж УБТЗ-ын төлөөлөгч АВХ-ээр шалгуулан санамжинд гарын үсэг зуралцсан байна.
- 4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс гарах хохирлыг хэн буруутай тал нь зохих журмын дагуу хүлээнэ. Хохирол барагдуулах талаар 2 тал харилцан зөвшилцөөгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.6. Гэрээнд заагдаагүй асуудлаар маргаан гарвал Төмөр замын тээврийн тухай хууль, бусад холбогдох хууль, дүрэм, заавар, хэлэлцээр, ачаа тээвэрлэлтийн тарифын мөрдлөгөд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хуулийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.
- 4.7. "Өртөөний хоногийн ажлын төлөвлөгөөт зурмаг"-т заагдсаны дагуу салбар замд сэлгээний илчит тэргээр үйлчлэх ба "Салбар замд ачаа ачиж, буулгах технологит ажиллагааг тогтоосон акт"-нд заасны дагуу ачааны ажиллагааг гүйцэтгэнэ.
- 4.8. Салбар зам эзэмшигч нь өөрийн салбар замынхаа техникийн бүрэн бүтэн байдал, дэр модны аж ахуйг хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагын хэмжээнд арчлуулах /арчлах/ ба салбар замын техникийн байдал, овор хэмжээ, MNS 5833:2014 Монгол

улсын стандартын шаардлага хангаагүйгээс хөдлөх бүрэлдэхүүн замаас гарах, ачаа нурах, унах, эвдрэх, осол, сүйрэл гологдол гарсан тохиолдолд бүх зардлыг салбар зам Эзэмшигч бүрэн хариуцна.

- 4.9. Гэрээний хэрэгжилтийн явцад “УБТЗ”-д хууль, дүрэм журмаар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд эзэмшигч нь саад учруулсан эсвэл гэрээний эрх, үүргийн хэрэгжилттэй холбоотойгоор аливаа маргаан, үл ойлголцол талуудын хооронд гарсан тохиолдолд энэхүү гэрээний биелэлтийг түдгэлзүүлэх, гэрээний хэрэгжүүлэлтийг буюу эзэмшигчийн замд вагон тавьж өгөх, татаж авахыг зогсоох шууд үндэслэл болох ба УБТЗ нь үүнээс үүдэн гарсан аливаа асуудалд хариуцлага хүлээхгүй.

Тав. Төлбөр тооцооны талаар.

- 5.1. Ачааг ачих болон буулгахаас өмнө тээвэрлэлттэй холбоотой зардлыг УБТЗ-ын дансанд урьдчилан байршуулсан байна.
- 5.2. Эзэмшигч нь салбар замд байцаагчийн хяналт тавьсны төлбөрийг тухайн оны 1-р улиралд багтаан бүтэн жилээр урьдчилан төлсөн байна.
- 5.3. Эзэмшигч нь төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,5 хувиар алдангийг төлнө.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1. Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана.
- 6.2. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Гэрээний хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- 7.1. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа уулзалтаар харилцан тохирсноос бусад тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.
- 7.2. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.3. Нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

Найм. Нууцыг хадгалах

- 8.1. УБТЗ-аас өгсөн аливаа нэг мэдээллийн нууцыг гэрээний хугацаа дууссан эсэхээс үл хамааран чанд хадгална.
- 8.2. Талууд зөвшөөрөлгүйгээр бүхий л бичиг баримт, тоо мэдээлэл, олж авсан болон цуглуулсан мэдээллээ ямар нэг байдлаар гэрээний үүргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.
- 8.3. Нууц хадгалах үүргээ биелүүлээгүйгээс УБТЗ-д ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулна.

Ес. Давагдашгүй хүчин зүйл

- 9.1. Хуульд заасан давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд үүргээ гэрээнд зааснаар гүйцэтгэх боломжгүй бол асуудлыг хуульд зааснаар шийдвэрлэнэ.
- 9.2. Олон улсын ачаа тээврийн харилцаанд урьдчилан төлөвлөгдөөгүй хүчин зүйлийн улмаас ачаа хүрэх хугацаа хэтэрсэн тохиолдолд УБТЗ гомдолыг хүлээн авч шийдвэрлэхгүй болно.

Арав. Гэрээ хүчин төгөлдөр болох

- 10.1. Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 /хоёр/ эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон хугацаанаас эхлэн 20... оны ... дугаар сарын ...ний өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ.
- 10.3. Эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, төмөр замын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа эсвэл салбар зам ашиглалт буюу арчлалтын гэрээний хугацаа энэхүү гэрээний 10.2 дах заалтад заасан хугацаанаас өмнө дуусгавар болсон, цуцлагдсан тохиолдолд энэхүү гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа тухайн гэрчилгээ, зөвшөөрөл эсвэл салбар зам ашиглалт, арчлалтын гэрээний хугацаа дуусгавар болсон буюу цуцлагдсан өдрөөс эхлэн дуусгавар болно.
- 10.4. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.
- 10.5. Гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө талууд гэрээг үйлчилсэн хугацаанд дүгнэнэ. Гэрээний үйлчлэх хугацааг сунгах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулж сунгана.
- 10.6. Энэ гэрээний 1.2-т заасан хавсралт болон бусад бичиг баримтууд дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзнэ.
- 10.7. Гэрээ болон түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

УБТЗ ХНН:

Хаяг:

Утас:

Э-мэйл :

Холбогдох /харьцах/ албан тушаалтан:

Салбар зам Эзэмшигч байгууллага:

Хаяг:

Утас:

Э-мэйл :

Холбогдох /харьцах/ албан тушаалтан:

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УБТЗ ХНН-ийг төлөөлж:

Эзэмшигчийг төлөөлж:

Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан

“БАЙГУУЛЛАГЫН НЭР”

замын орлогч дарга

/ албан тушаал/

Д.АМАРБАЯСГАЛАН

Д -

НЮ -

ДС -

КР -

ТАЛУУДЫН ХАЯГ

УБТЗ	Эзэмшигч
Хаяг:	Хаяг:
Утас:	Утас:
Факс:	факс:
Э-шуудан:	Э-шуудан:
Данс:	Данс:

Тооцоо нийлэх ажилтан

УБТЗ-ынөртөөний
тооцооны хэсгийн эрхлэгч / ДС,ДСК/

...../гэрээ байгуулах
байгууллага/-ийн нябо

Салбар замын техникийн байдал тогтоосон

акт

20..... оны-р сарын өдөр

..... өртөөний дарга, салбар зам эзэмшигчийн “.....” ХХК-ийн захирал, хэсгийн байцаагч, арчлалт хариуцсан нарын бүрэлдэхүүнтэй комисс, салбар зам ашиглах, арчлах, салбар замд сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах гэрээг “.....” ХХК-тай байгуулах зорилгоор салбар замд судалгаа хийж техникийн байдлыг тогтоон энэхүү актыг үйлдэв.

Нэг:Салбар зам эзэмшигч

Салбар зам эзэмшигчийн нэр:ХХК

Салбар зам эзэмшигчийн хаяг :

Улсын бүртгэлийн дугаар:

Утасны дугаар:

Хоёр:Салбар замын техникийн байдал:

1. Салбар замын дэлгэмэл урт : метр
2. Замуудын ашигтай урт:
3. Зориулалт:
4. Суман шилжүүлгийн тоо дугаар: гар сум 4ш, сум № 2,101, 103, 10
5. Салбар зам нь аль байгууллагын баланст байгаа: ХХК
6. Төмөр замын өртөөтэй нийлэх зам,сумын нэр дугаар:
7. Салбар замын хиймэл төхөөрөмж байгууламж:
8. Төмөр замын зурвас газрын дотор салбар зам эзэлсэн талбай:
9. Төмөр замын зурваст салбар зам эзэмшигчийн мэдлийн барилга байгууламжийн эзэлсэн газрын талбай:
10. Салбар замд хэний зүтгүүрээр үйлчилдэг:
11. Вагон тавилт, таталтын зай: метр
12. Вагон тавих, татах мэдээлэл солилцох утасны дугаар:
13. Салбар замд нэгэн зэрэг тавьж өгөх вагон тоо,замуудын багтаамж:

14. Салбар замд байгаа ачааны ачих, буулгах механизмын хүчин чадал, марк:

.....

15. Салбар зам нь ачаа жигнэх пүүтэй эсэх:

16. Салбар зам нь өөрийн схем зураг, паспорттой эсэх:

17. Салбар замд төмөр замтай огтлолцсон гарамтай эсэх:

18. Салбар замд вагоныг татах, түлхэх хэрэгсэл байгаа эсэх:

19. Салбар зам, сум, талбайн гэрэлтүүлэгтэй эсэх:

20. Салбар зам нь оврын шаардлага хангасан эсэх:

КОМИСС

УБТЗ ХНН-г төлөөлж:

..... өртөөний дарга

Салбар зам эзэмшигчийг төлөөлж:

..... ХХК-ийн захирал

...../нэр бичих/

...../нэр бичих/

.....хэсгийн байцаагч:

...../нэр бичих/

Салбар замын арчлалт, үйлчилгээ

хариуцсан:

...../нэр бичих/

Салбар замын техникийн байдал тогтоосон

акт

20..... оны -р сарын өдөр

..... өртөөний дарга, салбар зам эзэмшигчийн “.....” ХХК-ийн захирал, хэсгийн байцаагч, арчлалт хариуцсан нарын бүрэлдэхүүнтэй комисс, салбар зам ашиглах, арчлах, салбар замд сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах гэрээг “.....” ХХК-тай байгуулах зорилгоор салбар замд судалгаа хийж техникийн байдлыг тогтоон энэхүү актыг үйлдэв.

Нэг:Салбар зам эзэмшигч

Салбар зам эзэмшигчийн нэр:ХХК

Салбар зам эзэмшигчийн хаяг :

Улсын бүртгэлийн дугаар:

Утасны дугаар:

Хоёр:Салбар замын техникийн байдал:

1. Салбар замын дэлгэмэл урт : метр
2. Замуудын ашигтай урт:
3. Зориулалт:
4. Суман шилжүүлгийн тоо дугаар: гар сум 4ш, сум № 2,101, 103, 10
5. Салбар зам нь аль байгууллагын баланст байгаа: ХХК
6. Төмөр замын өртөөтэй нийлэх зам,сумын нэр дугаар:
7. Салбар замын хиймэл төхөөрөмж байгууламж:
8. Төмөр замын зурвас газрын дотор салбар зам эзэлсэн талбай:
9. Төмөр замын зурваст салбар зам эзэмшигчийн мэдлийн барилга байгууламжийн эзэлсэн газрын талбай:
10. Салбар замд хэний зүтгүүрээр үйлчилдэг:
11. Вагон тавилт, таталтын зай: метр
12. Вагон тавих, татах мэдээлэл солилцох утасны дугаар:
13. Салбар замд нэгэн зэрэг тавьж өгөх вагон тоо,замуудын багтаамж:

14. Салбар замд байгаа ачааны ачих, буулгах механизмын хүчин чадал,марк:

.....

15. Салбар зам нь ачаа жигнэх пүүтэй эсэх:

16. Салбар зам нь өөрийн схем зураг,паспорттой эсэх:

17. Салбар замд төмөр замтай огтлолцсон гарамтай эсэх:

18. Салбар замд вагоныг татах,түлхэх хэрэгсэл байгаа эсэх:

19. Салбар зам,сум,талбайн гэрэлтүүлэгтэй эсэх:

20. Салбар зам нь оврын шаардлага хангасан эсэх:

КОМИСС

УБТЗ ХНН-г төлөөлж:

..... өртөөний дарга

Салбар зам эзэмшигчийг төлөөлж:

..... ХХК-ийн захирал

...../нэр бичих/

...../нэр бичих/

.....хэсгийн байцаагч:

...../нэр бичих/

Салбар замын арчлалт, үйлчилгээ

хариуцсан:

...../нэр бичих/